



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 4/192

Улаанбаатар хот

Дархлаажуулалтын 10 хоногийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 472 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 19 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товллод орсон улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг нөхөн дархлаажуулалтын хамралт 23 хувь, хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралт 55 хувь, сахуу, татрангийн эсрэг дархлаажуулалтын 2 дахь тунгийн хамралт 72 хувьтай байгаа тул дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2025 оны 5 дугаар сарын 19-30-ны өдрүүдэд "Өнөөдрийн вакцин ирээдүйн хамгаалалт" уриан дор улсын хэмжээнд зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын 10 хоногоор заавал хийх дархлаажуулалтын товлолоос хоцорсон 15 хүртэлх насны хүүхдийг нөхөн дархлаажуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Э.Анхбаяр), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт, зохион байгуулалтад хүний нөөцийн дэмжлэг үзүүлэн ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл), бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтын ач холбогдлыг олон нийтэд таниулан сурталчлах ажлын нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Э.Анхбаяр), Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Л.Баттөр), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газарт даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

141251121